



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР
2023 ОН**

АГУУЛГА

НЭГ. ЗОРИЛГО	3
ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ	3
ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ.....	4
3.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн үнэлгээ.....	4
3.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	6
3.3.Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ	7
3.4.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	7
3.5.Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ.....	8
3.6.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ	10
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	10
4.1.Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн үнэлгээ.....	10
4.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ	10
4.3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	11
ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ.....	11
5.1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	11
5.2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	12
5.3.Шударга байдлын түвшний үнэлгээ.....	12
5.4.Хэрэглэгчийн үнэлгээ	12
ЗУРГАА.ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	13
6.1.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ.....	13
ДОЛОО. ДҮГНЭЛТ.....	13
НАЙМ. ЗӨВЛӨМЖ	14

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ. ЗОРИЛГО

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, цаашид шийдвэр гаргах түвшинд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналыг сайжруулж, улмаар түүний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх хэсэгт заасан “хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлан, мэдээлэл ирүүлэх, явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, Засгийн газарт танилцуулах” гэж заасныг үндэслэл болгож хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг үнэлэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”¹, байгууллагын нээлттэй, ил тод байдлыг үнэлэхдээ Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг тус тус баримтлав.

Бодлогын баримт бичиг болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дээрх журмын 6.2.1-д зааснаар хувиар илэрхийлэн үнэлсэн, харин тоо, чанараар илэрхийлэх боломжгүй зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг мөн журмын 6.2.2-т заасан аргачлалаар, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон байгууллагын ил тод байдлыг хангах үйл ажиллагааг дээрх журмын 6.3-д заасан аргачлалаар тус тус үнэлэв.

Шударга байдлын түвшний үнэлгээ, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.6-д “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар жил бүр төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг ... хийх ажлыг зохион байгуулна..”, 9.7-д “Авлигатай тэмцэх газраас гаргасан шударга байдлын түвшингийн үнэлгээ нь захиргааны байгууллагын үнэлгээний нэг үзүүлэлт болно”, 9.8-д “Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор хүргүүлнэ” гэж заасны дагуу Сангийн яамны “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 оны шилэн данс хөтлөлтийн байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”, Авлигатай тэмцэх газрын “Шударга байдлын үнэлгээ” судалгааны тайлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгийн 2022 онд хийсэн “Төрийн бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа”-ны дүнг тус тус үнэлгээнд оруулан тооцов.

Үнэлгээ хийх журамд заасны дагуу ерөнхий үнэлгээг тооцохдоо:

- ✓ бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээнд орсон 5 үзүүлэлтийн дундаж нь нийт үнэлгээний 50 хувь;

¹ Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон

- ✓ байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээнд орсон 3 үзүүлэлтийн дундаж нь нийт үнэлгээний 15 хувь;
- ✓ байгууллагын нээлтэй байдлын үнэлгээнд орсон 4 үзүүлэлтийн дундаж нь нийт үнэлгээний 20 хувь;
- ✓ Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээнд орсон 1 үзүүлэлт нь нийт үнэлгээний 15 хувь болно.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээнд:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;
- Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт;
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт.

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээнд:

- Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт;
- Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт;
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт.

Байгууллагын нээлтэй байдлын үнэлгээнд:

- Байгууллагын ил тод байдал;
- Шилэн дансны хөтлөлт;
- Шударга байдлын түвшний үнэлгээ;
- Хэрэглэгчийн үнэлгээ.

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээнд:

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлтийн дүн зэрэг 13 үзүүлэлтийг тооцсон.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тус аймгаас цаасан болон цахим хэлбэрээр ирүүлсэн тайланд тулгуурласны зэрэгцээ бусад холбогдох баримт бичиг, статистик мэдээлэлтэй зохих харьцуулалт хийж, 2021 онд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг харгалзан үзсэн болно.

ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн үнэлгээ

Тус аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар хууль болон УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар үүрэгжүүлэн өгсөн нийт 111 зүйл, заалтын хэрэгжилтийг хянан үзэж, **82.7 хувиар** үнэлэв.

Хүснэлт 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн, 2022 он

Эрх зүйн актын төрөл	Нийт	Үнэлгээ /заалтын тоо/				Дундаж үнэлгээ /%/
		Бүрэн хэрэгжсэн 100%	Хэрэгжих шатанд 70%	Хэрэгжилт хангалтгүй 30%	Хэрэгжээгүй 0%	
Монгол Улсын хууль	66	58	8	-	-	96.4

УИХ-ын байнгын хорооны тогтоол	2	1	1	-	-	85.0
Ерөнхийлөгчийн зарлиг	14	1	7	6	-	55.0
ҮАБЗ-ийн зөвлөмж	6	1	2	3	-	55.0
Засгийн газрын тогтоол	11	3	6	-	2	65.5
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	10	2	7	-	1	69.0
Засгийн газрын албан даалгавар	2	-	2	-	-	70.0
Нийт	111	66	33	9	3	82.7
Үнэлгээнд эзлэх хувь	100.0	59.5	29.7	8.1	2.7	

Эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалтуудаас хэрэгжилт хангалтгүй 9, хэрэгжээгүй 3 заалт байна. Тухайлбал:

Хэрэгжилт хангалтгүй:

1) Ерөнхийлөгчийн 2018 оны "Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай" 46 дугаар зарлигийн 3-т "Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллах";

2) Ерөнхийлөгчийн 2021 оны "Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/" 58 дугаар зарлигийн 1.2-т "Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах", 1.6-д "Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох", 1.7-д "Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах", 1.8-д "Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх", 2-т "Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулах";

3) ҮАБЗ-ийн 2010 оны "Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай" 10/09 дүгээр зөвлөмжийн 1-д "Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх" зэрэг заалтын хэрэгжилт хангалтгүй байна. (Дэлгэрэнгүйг www.new.unelgee.gov.mn цахим мэдээллийн сангаас харна уу.)

Хэрэгжээгүй заалт:

1) Засгийн газрын 2022 оны "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 204 дүгээр тогтоолын 9-д заасан "Автомашин хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх";

2) Засгийн газрын 2022 оны "Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 419 дүгээр тогтоолын 4-д заасан "Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллах";

3) Засгийн газрын 2022 оны 49 дүгээр хуралдааны тэмдэглэлийн XII.5.2-т заасан "Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллах" заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 4 бодлогын 17 арга хэмжээний хэрэгжилтийг хянан үзэж, **67.7 хувиар** үнэлэв.

Хүснэгт 2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтийн үнэлгээ

Хэрэгжүүлсэн бодлого	Нийт	Үнэлгээ арга хэмжээний тоогоор				Дундаж үнэлгээ /%/
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
Засаглалын бодлого	3	2	1	-	-	90.0
Нийслэл ба бус, орон нутгийн хөгжлийн бодлого	6	-	5	1	-	66.7
Ногоон хөгжлийн бодлого	3	1	1	1	-	73.3
Эдийн засгийн бодлого	5	1	-	4	-	52.0
Нийт	17	4	7	6	-	67.7
Үнэлгээнд эзлэх хувь	100.0	24.0	41.0	35.0	-	

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд эрчимжүүлэх шаардлагатай дараах арга хэмжээнүүд байна:

1) [6.2.13] Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

2) [3.7.12] Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

3) [3.3.6] Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх;

4) [3.7.9] Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе шаттай эхлүүлэх;

5) [5.1.4] Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулах;

6) [6.2.13] Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг болно.

3.3.Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ²

Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 8 бүлэг, 37 зорилтын хүрээнд 121 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тус үндсэн чиглэлийн 2022 оны хэрэгжилтийг хянан үзэж, **81.5 хувиар** үнэлэв.

Хүснэгт 3. Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ, 2022 он

№	Үндсэн чиглэл	Зорилт	Арга хэмжээ	Биелэлтийн хувь						Дундаж үнэлгээ /%/	
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	100	90		70
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	2	4	3	-	1	-	-	-	-	92.5
2	Хүний хөгжил	7	33	12	7	10	4	-	-	-	81.7
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	5	13	8	1	3	1	-	-	-	88.5
4	Эдийн засаг	5	13	7	2	3	-	-	1	-	83.5
5	Засаглал	6	11	5	6	-	-	-	-	-	94.5
6	Ногоон хөгжил	4	14	4	3	3	3	-	1	-	73.6
7	Амар тайван, аюулгүй нийгэм	4	12	9	-	3	-	-	-	-	92.5
8	Бүс, орон нутгийн хөгжил	4	21	4	4	3	5	4	1	-	63.8
Нийт		37	121	52	23	26	26	4	3	3	81.5

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн хувьд эрчимжүүлэх шаардлагатай 30, үр дүнгүй 3 арга хэмжээ байна. Тухайлбал:

1) [4.2.1] Хүнд үйлдвэрийн бүс байгуулж, боловсруулах үйлдвэр байуулахыг бодлогоор дэмжинэ.

2) [6.3.3] Аймаг, сумдын төвийн ундны усны эх үүсвэрт нөөцийн судалгаа хийнэ.

3) [8.1.4] Хэрлэн голын Хөмөлтэйн гүүр, Чойр-Мандалговь чиглэлийн авто замын ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллана.

4) [8.1.2] Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд авто үйлчилгээний төв байгуулана.

5) [8.1.3] Дэд бүтцэд тулгуурлан тээвэр, логистикийн төв байгуулна.

6) [8.1.5] Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

7) [8.1.8] Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний өөрчлөлт болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийлгэнэ зэрэг арга хэмжээ байна. (Дэлгэрэнгүйг www.new.unelgee.gov.mn цахим мэдээллийн сангаас харна уу.)

Санхүүжилтийн гүйцэтгэл: Үндсэн чиглэлд тусгагдсан 121 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2022 онд 199.3 тэрбум төгрөг төсөвлөж, 119.4 тэрбум төгрөг буюу 60.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.4.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

² Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар хавсралтад заасны дагуу Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын жилийн үйл ажиллагааны үнэлгээнд Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ ороогүй болно.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь 6 бодлогын хүрээнд 212 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тус үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтийг хянан үзэж, **75.3 хувиар** үнэлэв.

Хүснэгт 4. Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт

Хэрэгжүүлсэн бодлого	Нийт	Үнэлгээ арга хэмжээний тоогоор				Дундаж үнэлгээ /%/
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
"Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	10	7	3	-	2	91.0
Хүний хөгжлийн бодлого	50	20	17	7	18	73.2
Эдийн засгийн бодлого	75	29	25	15	8	73.6
Засаглалын бодлого	53	32	11	5	6	80.4
Ногоон хөгжлийн бодлого	13	4	6	1	2	70.0
Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	11	3	4	3	-	64.5
Нийт	212	95	66	31	36	75.3
Үнэлгээнд эзлэх хувь		44.8	31.1	14.6	12.7	

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Дээрх үйл ажиллагааны ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс үр дүнгүй хэрэгжсэн буюу 0-30 хувийн хэрэгжилттэй 36, эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-69 хувийн хэрэгжилттэй 31 арга хэмжээ байна. Тухайлбал:

- 1) [2.2.2.2] Шивээговь суманд Соёлын төв, Баянтал суманд соёл спортын цогцолборыг барина;
- 2) [2.2.3.3] Усан бассейн бүхий спорт цогцолбор барина;
- 3) [2.3.3.4] Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн 320 хүүхдийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулна;
- 4) [2.5.6.6] "Ахмадын өргөө"-ний барилгыг шинээр барьж, ахмад настны хөгжлийн төвийг байгуулан, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана;
- 5) [2.5.7.7] Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна;
- 6) [2.6.6.8] Боржигин өв музейн, Нийтийн номын сангийн байрыг засварлана;
- 7) [3.2.1.1] Хүнд үйлдвэрийн бүс байгуулж, боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ;
- 8) [3.2.2.2] Орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа хууль зөрчсөн аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах арга хэмжээг авна;
- 9) [3.3.10.29] Бизнес эрхлэгчдийг олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулан инноваци, тоног төхөөрөмжийг нэвтрүүлнэ;
- 10) [3.3.4.14] Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, ган, зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөгөөтэй, үе шаттай хэрэгжүүлнэ;
- 11) [3.3.8.26] Шинэ хөдөө төслийг хэрэгжүүлнэ;
- 12) [3.5.2.4] Сумдын төвийн халаалтын зуухыг өргөтгөнө;
- 13) [4.1.1.1] Хөдөөгийн багуудыг интернет сүлжээнд холбох ажлыг бодлогоор дэмжинэ;
- 14) [4.2.1.3] Төрийн захиргааны байгууллагуудын барилгын ажлуудыг эхлүүлнэ зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна. (Дэлгэрэнгүйг www.new.unelgee.gov.mn цахим мэдээллийн сангаас харна уу.)

3.5. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

Говьсүмбэр аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан 6 бодлого, 137 зорилт, 196 арга хэмжээний хэрэгжилтийг хянан үзэж, **72.8 хувиар** үнэлэв. Нийт арга хэмжээний 32.6 хувь нь үр дүнтэй хэрэгжсэн, 39.8 хувь тодорхой үр дүнд хүрсэн, 20.4 хувь эрчимжүүлэх шаардлагатай, 7.1 хувь үр дүнгүй хэрэгжсэн байна.

Хүснэгт 5. Хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ /хөгжлийн бодлогоор/, 2022 он

Хөгжлийн бодлого	Хэрэгжилтийн хувь				Нийт	Дундаж үнэлгээ /%/
	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй		
"Ковид-19" цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулах бодлого	5	5	-	-	10	89.0
Хүний хөгжлийн бодлого	14	19	10	5	48	71.5
Эдийн засгийн бодлого	15	28	22	6	71	63.9
Засаглалын бодлого	23	17	3	2	45	84.4
Ногоон хөгжлийн бодлого	3	6	3	-	12	75.8
Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	4	3	2	1	10	71.0
Нийт	64	78	40	14	196	72.8
Үнэлгээнд эзлэх хувь	32.6	39.8	20.4	7.1	-	-

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс эрчимжүүлэх шаардлагатай 40 арга хэмжээ, хэрэгжээгүй буюу үр дүнгүй хэрэгжсэн дараах 14 арга хэмжээ байна:

- 1) [23] Усан бассейн бүхий спорт цогцолбор барина.
- 2) [25] Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн сургууль, цэцэрлэгийн барилгыг ашиглалтанд оруулна.
- 3) [29] Сургууль, цэцэрлэг, дотуур байрны их засварын ажлыг үе шаттайгаар хийнэ.
- 4) [44] "Ахмадын өргөө"-ний барилгыг шинээр барьж, ахмад настны хөгжлийн төвийг байгуулан, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 5) [53] Боржигин өв музей, Нийтийн номын сангийн байрыг засварлана.
- 6) [67] Хүнд үйлдвэрийн бүс байгуулж, боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- 7) [68] Орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа хууль зөрчсөн аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах арга хэмжээг авна.
- 8) [81] Байгалийн хадлан бэлтгэж, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, тэжээлийн нөөц бүрдүүлнэ.
- 9) [140] Байгаль орчин, Мэргэжлийн хяналтын газрын барилгын ажлын төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлнэ.
- 10) [125] Сүмбэр сумын төвд дахин төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.
- 11) [116] Хэрлэн голын Хөмөлтэйн гүүр, Чойр-Мандалговь чиглэлийн авто замын зураг төсвийг хийлгэж, барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлнэ.
- 12) [112] Аймгийн төвд авто үйлчилгээний төв байгуулна.
- 13) [157] Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв байгуулна.
- 14) [195] Хотын захирагчийн ажлын алба байгуулж, үйл ажиллагааг бэхжүүлнэ.

Аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан 196 арга хэмжээг 7.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд үүний 76.5 хувийг улсын төсвийн хөрөнгөөр, 13.7 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр, 9.7 хувийг тусгай сангийн хөрөнгөөр, 0.1 хувийг бусад эх үүсвэрээр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Санхүүжилтийн гүйцэтгэлээр нийт 7.0 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн нь нийт төлөвлөсөн дүнгийн 97.6 хувийг эзэлж байна.

3.6.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ

Говьсүмбэр аймгийн 2022 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн 44 үзүүлэлтийн биелэлтийг Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (1212.mn), Байгаль орчин, аялал жуулчлал яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв зэрэг байгууллагын цахим хуудсанд байршуулсан мэдээлэлтэй тулгаж хянаж, зөрүүг харгалзан үнэлгээг бууруулан **86.5 хувиар** үнэлэв.

Хүснэгт 6. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ, 2022 он

Д/д	Зөрүүтэй шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин	Аймгаас ирүүлсэн	Бодит гүйцэтгэл	Үнэлгээ /%/
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн	тэрбум.төг	121.4	-	155.3	90.0
2	10.000 хүн амд вируст гепатитын өвчлөл	тоо	0.0	2.2	3.1	0.0

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.1.Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн үнэлгээ

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2022 онд Засгийн газрын гишүүдтэй байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний биелэлтийн дундаж **85.8 хувь** байна.

Хүснэгт 7. Засгийн газрын гишүүдтэй байгуулсан гэрээний биелэлт, 2022 он /хувиар/

Засгийн газрын гишүүн	Биелэлтийн хувь	Засгийн газрын гишүүн	Биелэлтийн хувь
Эрчим хүчний сайд	98.5	Сангийн сайд	85.1
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	98.1	Эрүүл мэндийн сайд	84.5
Гадаад харилцааны сайд	94.0	Батлан хамгаалахын сайд	82.2
Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	92.9	Соёлын сайд	80.5
Хууль зүй, дотоод хэргийн сайд	92.5	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	79.0
Боловсрол, шинжлэх ухааны сайд	91.0	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	77.5
Эдийн засаг, хөгжлийн сайд	87.8	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	72.9
Барилга, хот байгуулалтын сайд	87.2	Зам, тээврийн хөгжлийн сайд	68.6

Эх сурвалж: Яамд

4.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

Аймгийн Засаг даргын Тамгын газар 2022 онд 27 зорилтын хүрээнд 198 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан үзэж, **75.1 хувиар** үнэлэв.

Хүснэгт 8. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ, 2022 он

№	Чиглэл	Зорилт	Арга хэмжээ	Биелэлтийн хувь						Дундаж үнэлгээ /%/
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	
					100	90	70	50		
1	Ногоон хөгжлийн бодлого	4	39	12	7	14	6	-	-	79.7
2	Төрийн үйлчилгээний чанар үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилт	4	30	9	6	6	4	2	3	70.7
3	Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	1	11	7	1	3	-	-	-	90.9

4	Хуулиар олгосон хэрэгжүүлэх хэмжээ	тусгайлан чиг үүргийг зорилт, арга	2	14	12	1	-	-	-	1	92.1
5	Хүний хөгжлийн бодлого		8	39	21	2	13	1	-	2	83.1
6	Эдийн засгийн бодлого		8	65	15	9	13	13	8	7	63.2
Нийт			27	198	76	26	49	24	10	13	75.1

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлтийн тайланг хянан үзэхэд, гүйцэтгэлийн төлөвлөгөө стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй уялдаагүй, зорилт арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй буюу хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжих тоон ба чанарын утгыг тодорхойлоогүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаагаагүй, арга хэмжээ бүрийг тоочих байдлаар тайлагнасан, үр дүн, хэрэгжилтийг бүрэн тайлагнаагүй зэрэг дутагдалтай асуудлууд байна.

4.3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 зорилт, 7 арга хэмжээний хэрэгжилтийг хянан үзэж, **91.4 хувиар** үнэлэв.

Хүснэгт 9. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, хувиар

Зорилт	Үйл ажиллагаа	Үнэлгээ /%/
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх	1.Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	100.0
	2.Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	70.0
	3.Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	100.0
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	4.Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	90.0
	5.Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	90.0
	6.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	90.0
	7.Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	100.0
Дундаж үнэлгээ		91.4

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

5.1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны ил тод байдлыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн 5 төрлийн 46 мэдээлэл тус бүрээр хянан үзэж, **54.6 хувиар** үнэлэв. Энэ нь аймгуудын дундаж үнэлгээнээс 8.1 нэгж хувиар илүү байна. Нийт 46 мэдээллийн 29 нь 70.0 хувь, 12 мэдээлэл 0-30.0 хувийн хэрэгжилттэй, 5 мэдээлэл хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй буюу үнэлэгдээгүй байна.

График 1. Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ (мэдээллийн төрлөөр)



Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Тус байгууллага хүний нөөцийн болон төсөв, санхүүгийн мэдээллийг бусад төрлийн мэдээллээс илүү нээлттэй мэдээлдэг. Харин худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл, төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн, төрийн болон орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд,

байгууллагын зардлаар суралцагчийн талаарх мэдээллийг хангалтгүй мэдээлж байна.

5.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Сангийн яамны “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 оны шилэн данс хөтлөлтийн байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”-д тусгагдсанаар Говьсүмбэр аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 39 байгууллага дунджаар 153 удаа мэдээлэл байршуулахаас 148 удаа мэдээллийг байршуулж, шилэн данс хөтлөлтийн үнэлгээ **98.4 хувь** байна.

Хүснэгт 10. Шилэн данс хөтлөлтийн үнэлгээ, 2022 он

Төсвийн ерөнхийлөн захирагч	Говьсүмбэр аймгийн Засаг дарга	
Харьяа байгууллагын тоо	39	
Нэг байгууллага дунджаар мэдээлэл байршуулах давтамжийн тоо	байршуулах	153
	байршуулсан	148
Хугацаанд нь мэдээлэл байршуулсан байдал	хугацаанд нь байршуулсан	138
	хугацаа хоцроосон	10
Үнэлгээ /%/	98.4	

Эх сурвалж: Сангийн яам

5.3. Шударга байдлын түвшний үнэлгээ

Авлигатай тэмцэх газрын 2022 оны шударга байдлын үнэлгээгээр Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар **69.5 хувиар** үнэлэгдэж, өмнөх онтой харьцуулахад, 0.7 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 11. Аймгийн 2021, 2022 оны шударга байдлын үнэлгээ /%/


Байгууллагын нэр	Шударга байдлын үнэлгээ	
	2021	2022
Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар	68.8	69.5
Улсын дундаж	72.9	73.9

Эх сурвалж: Авлигатай тэмцэх газар

5.4. Хэрэглэгчийн үнэлгээ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын захиалгаар IRIM судалгааны хүрээлэн 2022 оны төрийн бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг хийсэн байна. Уг судалгаагаар Говьсүмбэр аймгийн иргэдийн төрийн үйлчилгээнд өгсөн үнэлгээ нь **65.0 хувь** буюу аймаг, нийслэлийн ерөнхий дунджаас дээгүүр үнэлэгдсэн байна.

График 2. Төрийн үйлчилгээний үнэлгээ



Эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Түүвэр судалгаагаар тухайн аймагт цахим засаглалтай холбогдох үйлчилгээ хамгийн өндөр үзүүлэлттэй үнэлэгдсэн бол уул уурхайн нөхөн сэргээлттэй холбогдолтой асуудалд иргэд сэтгэл ханамж муу буюу хангалттай үйл ажиллагаа хэрэгжихгүй байна гэж үзсэн байна.

ЗУРГАА.ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

6.1.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ **77.6 хувь** байна.

Хүснэгт 12.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ

№	Үнэлгээ	Нийт	Ногоон байгууламж	Цахим шилжилт	Хог хаягдлын менежмент
1	Зорилтын тоо	3	1	1	1
2	Шалгуур үзүүлэлтийн тоо	9	3	4	2
3	Бүрэн хэрэгжсэн /90-ээс дээш/	3	1	2	-
4	Бүрэн хэрэгжээгүй /90-ээс доош/	5	2	1	2
5	Хугацаа болоогүй	1	-	1	-
Хэрэгжилтийн ерөнхий дүн		77.6	84.1	95.3	53.4

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Төрийн бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа 2022 он.

ДОЛОО. ДҮГНЭЛТ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу тус аймгийн бодлогын баримт бичгийн болон хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгтгэн дүгнэв.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дундаж **77.0** хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээний дундаж **84.1** хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээний дундаж **71.9** хувь, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилт **77.6** хувь, ерөнхий үнэлгээ **77.13** хувь байна.

Хүснэгт 13.Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны үнэлгээний дүн

№	Үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт
		Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
		82.7
		67.7

		Говьсүмбэр аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	75.3
		Говьсүмбэр аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт	72.8
		Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт	86.5
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	85.8
		Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	75.1
		Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	91.4
3	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Байгууллагын ил тод байдал	54.6
		Шилэн дансны хөтлөлт	98.4
		Шударга байдлын түвшин	69.5
		Хэрэглэгчийн үнэлгээ	65.0
4	Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэл	Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт	77.6
Оноо			3.86
Ерөнхий үнэлгээ			77.13

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй 12 заалт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр үр дүнгүй гэж үнэлэгдсэн нийт 66 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн нийт 141 арга хэмжээ тус бүрийг хяналтад авч, хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийж, 2023 оны төлөвлөгөөнд нэмэлтээр тусган хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээ авах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, сахилга хариуцлагыг дээшлүүлэх нь зүйтэй байна.

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын мөн оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтад заасан аргачлалын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодитой, биелэгдэхүйц, шалгуур үзүүлэлт нь тодорхой, хэмжигдэхүйц байхаар төлөвлөх, гүйцэтгэлийн тайлан нь иж бүрэн, алдаа мадаггүй, илтгэл үнэмшил төрүүлэхүйц үр дүнд суурилсан байхад анхаарах шаардлагатай байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуульд заасан мэдээллийг ил тод, нээлттэй болгож, иргэдийг үнэн зөв, бүрэн, ойлгомжтой мэдээллээр хангах, мэдээллийн үйлчилгээг шуурхай, хялбар болгоход анхаарч, хуулийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

НАЙМ. ЗӨВЛӨМЖ

Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн цаашид дор дурдсан асуудалд анхаарал хандуулж, удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Зөвлөмж болгож байна.

Бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах талаар:

1. Бодлогын баримт бичгийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасан судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмын хүрээнд тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явц, үе шат, хэрэгжих хугацаа, гарах үр дүн, өмнөх жилийн гүйцэтгэл, тулгамдаж байгаа асуудал зэргийг нарийвчлан судалж, судалгааны үр дүнг төлөвлөлтөд ашиглаж хэвших;

2. Хөгжлийн бодлогын зорилго, зорилт, арга хэмжээг үр дүнд чиглүүлж, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг тодорхой, оновчтой, үр дүнг илэрхийлэхүйц, хэмжих боломжтой байдлаар тодорхойлох;

3. Бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, түүний эх үүсвэрийг үндэслэл, тооцоо, судалгаанд үндэслэн бодитой төлөвлөх;

4. Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5.2.13-д заасны дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэд, сонирхлын бүлгийн оролцоог хангаж ажиллах;

5. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг боловсруулахдаа тухайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллаж, эдийн засаг, нийгмийн төлөв байдлын талаарх албан ёсны статистик үзүүлэлтэд суурилж, салбарын бодлоготой уялдуулан аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн онцлогийг харгалзан тодорхойлох.

Бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах талаар:

1. Бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, хэрэгжилт удаашралтай, хангалтгүй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, тухайн жилийн хэрэгжилтийг бүрэн хангах;

2. Бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, хэрэгжилтийг үр дүнд чиглүүлэн зохион байгуулж, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэж ажиллах;

3. Монгол Улсын хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцогч талуудтай хамтарч ажиллах.

Хэрэгжилтийн тайлагналыг сайжруулах талаар:

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг богино хугацааны үр дүн, дунд хугацааны үр нөлөөг илэрхийлэх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн, үнэн зөв тайлагнаж байх;

2. Санхүүжилтийн гүйцэтгэл, эх үүсвэрийг арга хэмжээ бүрээр бүрэн тайлагнаж, жилийн эцсийн байдлаарх өссөн дүнг хагас жилийн гүйцэтгэлтэй тулган хянаж байх;

3. Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.new.unelgee.gov.mn мэдээллийн цахим санд тухайн арга хэмжээний хэрэгжилтийг баталгаажуулах нотлох баримтыг хавсаргаж байх;

4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг тайлагнахдаа Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын

3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг баримтлах;

5. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн гүйцэтгэлийн мэдээлэлд шалгуур үзүүлэлт бүрийн албан ёсны эх сурвалжийг оруулах.

Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах талаар:

1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.12-т заасны дагуу байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарыг заавал ажиллуулж, цахим хуудсаар нээлттэй мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангах,

2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах арга хэмжээ авч ажиллах;

3. Байгууллагын цахим хуудсыг "Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 6285:2017 стандарт"-ын дагуу хөтөлж, хэвшүүлэх.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, үр нөлөөг сайжруулах талаар:

1. Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах үйл явцад хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх;

2. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, суурь түвшин болон зорилтот түвшин, хүрсэн үр дүнг үндэслэн үнэн зөв, бодитой үнэлэх;

3. Бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн оролцоотойгоор хөндлөнгийн үнэлгээ хийж, аймгийн удирдлага болон хариуцсан нэгжид дүгнэлт, зөвлөмж хүргүүлж, хамтран ажиллах зэрэг болно.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР